



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 11 өдөр

Дугаар A/205

Булган

“Нэг суурин-Нэг бахархал” аян өрнүүлэх тухай


Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Засгийн газрын үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.48.12, 2.52.3 дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны А-453 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн түүхий эд, нөөц баялгийг ашиглан брэнд бүтээгдэхүүнийг илрүүлэх, бий болгох, Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүн үйл ажиллагааг зах зээлд нэвтрүүлэх, шинэ зах зээл, шинэ түншлэл бүхий олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, импортыг орлохуйц бүтээгдэхүүн, экспортын барааны нэр төрлийг олшруулах, өрсөлдөх чадварыг бий болгох, хүн амыг эрүүл аюулгүй, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах зорилтын хүрээнд “Нэг суурин-Нэг бахархал” аяныг аймаг, орон нутгийн хэмжээнд жилийн хугацаанд өрнүүлсүгэй.

2. “Нэг суурин-нэг бахархал” аяныг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээг сумдын Засаг даргын Тамгын газар, төр, хувийн хэвшлийн байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран үр дүнтэй зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар ханган, хэрэгжилтэд хяналт тавьж, шаардагдах зардлыг холбогдох байгууллагуудын төсвөөс санхүүжүүлж, үр дүнг аймгийн Засаг даргын дэргэдэх Зөвлөлийн хурал, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдад тайлагнахыг ажлын хэсэг /О.Гантулга/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190210

Аймгийн Засаг даргын 2019 оны 04 сарын
11 өдрийн 4605 тоот захирамжийн хавсралт

"НЭГ СУУРИН - НЭГ БАХАРХАЛ" АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: О.Гантулга /аймгийн Засаг даргын орлогч/

Гишүүд:

- Д.Буманбаяр /Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн

дарга/

- Ч.Амгалан /Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга/

- Н.Батжаргал /Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын дарга/

- Ц.Бүрэнтуяа /Стандарт хэмжилзүйн хэлтсийн дарга/

- М.Бадам /Стандарт хэмжилзүйн хэлтсийн Баталгаажуулалтын шинжээч/

- Д.Мэндсайхан /Ажил олгогч эздийн холбооны тэргүүн/

- Ч.Сарантуяа /Аймгийн Тогооч нарын холбооны тэргүүн/

- Д.Пүрэвзаяа /Аймгийн Хүнсчдийн холбооны тэргүүн/

- Д. Оюунгэрэл /Худалдаа аж үйлдвэрийн танхимын тэргүүн/

- Сумын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга: - Ч.Оюун-Эрдэнэчимэг /ХОХБТХ-ийн Үйлдвэрлэл, үйлчилгээ,
аялал жуулчлалын салбарын бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн/